

ЗӨВЛӨМЖ

*Нийгмийн даатгалын сангийн чөлөөт
үлдэгдлээс арилжааны банкуудад мөнгөн
хадгаламж хэлбэрээр байршуулсан
хөрөнгийн гэрээний хугацааг сунгах тухай*

2026 оны 04 дүгээр сарын 27

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01/962 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлт болон мөн оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 01/1123 дугаар албан бичгээр ирүүлсэн тодруулга, баримт бичгүүдтэй Мэргэжлийн хорооны гишүүд танилцан, судалж үзээд 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, дараах зөвлөмжийг өгч байна.

Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангуудын чөлөөт үлдэгдлээс 2025 онд системийн нөлөө бүхий арилжааны нэр бүхий банкуудад байршуулсан 700,0 тэрбум төгрөгийн хадгаламжийн гэрээ / 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хаан банкт байгуулсан МХ-03/618 дугаартай гэрээ, Худалдаа хөгжлийн банкт байгуулсан МХ25-01 дугаартай гэрээ, Голомт банкт байгуулсан МХ25-02, ББГ2025/02-173 дугаартай гэрээ, Төрийн банкт байгуулсан МХ25-04, 08-01/190 дугаартай/-ний хугацаа 2026 оны 05 дугаар сарын 02-ны өдөр дуусгавар болох тул Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.9-д заасныг үндэслэн нэг жилээр сунгахад хууль эрх зүйн талаас ямар нэгэн зөрчилгүй бөгөөд эрсдэл багатай гэж үзлээ.

2. Дээрх гэрээнүүдийн хугацааг сунгахдаа арилжааны нэр бүхий банкуудаас 2026 онд ирүүлсэн хадгаламжийн хүүгийн санал, НДҮЗ-ийн 2026 оны 05 дугаар тогтоолоор баталсан хүүгийн доод хэмжээнээс бууруулахгүй байх зарчим баримтлах;

3. Цаашид нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл жил ирэх тутамд өсөж арилжааны банканд байршуулах боломжит хөрөнгийн хэмжээ “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн 13.1.4-т заасан хэмжээнд хүрч хязгаарлагдахаар байх тул эрсдэл бага, өгөөж өндөртэй санхүүгийн бусад хэрэгсэлд байршуулах боломжийг судлан, хууль эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах саналыг эрх бүхий газруудад хүргүүлэх;

4. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг арилжааны нэр бүхий нэг банканд байршуулахад “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-ийн 13.1.4-т заасан хязгаарлалтад хамаарах эсэхийг шийдвэрлэх шаардлага үүсэж байгааг анхаарах нь зүйтэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
дэргэдэх Мэргэжлийн хороо